

Жилийн тайлан

МОНГОЛБАНКНЫ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



Б.Лхагвасүрэн
Монголбанкны Ерөнхийлөгч

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Суурь конвенцийн Парисын хэлэлцээрийг 2016 онд соёрхон баталж, 2030 он гэхэд үндэсний хүлэмжийн хийн ялгарлыг 22.7%-аар бууруулах зорилтыг тавьсан. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд оролцох үеэр үндэсний хэмжээнд “Тэрбум мод” тарих хөдөлгөөнийг эхлүүлсэн талаар мэдэгдэж, эх дэлхийнхээ өмнө Монголчууд бид томоохон үүрэг хариуцлагыг хүлээж байна.

Энэхүү үндэсний хэмжээний том зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс Монголбанк бодлогын түвшинд дэмжиж, банкны салбар нэгдэн нийлснээр “Тэрбум Мод Сан”-г байгуулсан. Энэхүү сан үйл ажиллагаагаа эхлүүлээд нэг жилийн нүүрийг үзэж байгаа ч чамгүй олон амжилтыг гаргаад байна. Сангийн хувьд төслийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, олон шатлалт шалгуураар зохион байгуулж, шалгарсан төслүүдийн хүрээнд энэ оны 5 дугаар сараас хойш 50,000 гаруй модыг тарьж, 85%-тай ургаж байгаа тоо, мэдээ гарсан. Энэ нь бусад салбарынханд нэг сайн жишиг болж байгаа гэдэгт итгэлтэй байна. Сангаас хэрэгжүүлж буй төслүүд нь экологийн болон иргэдийн амьдралд өдөр тутамд нь үр шимээ өгөх өндөр ач холбогдолтой дээр

төсөл хэрэгжүүлэгчид ч тухайн орон нутгаа ногооруулж, нутгийнхаа иргэдийг мод тарихад уриалан манлайлж байгаа нь тун сайшаалтай.

Цаашид банкны салбарын том санаачлагуудын нэг болох “Тэрбум Мод Сан” нь шинэ, шинэлэг төслүүдийг санхүүжүүлэн, ойн салбарт олон шинэ дэвшил, өөрчлөлтийг түүчээлнэ гэдэгт итгэлтэй байна.

“Тэрбум Мод Сан”-гийн ажлын алба болон үүсгэн байгуулагч Монголын Банкны Холбоо, Тос Холбоо, хандивлагч банкуудын цаашдын тэрбум мод тарих үйлсэд өндөр амжилт хүсэн ерөөе.

Эх дэлхийн ногоон хөгжилд хамтдаа бодит хувь нэмэр оруулцгаая!

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Л.Амар

Тэрбум мод сангийн 2022 оны
Удирдах зөвлөлийн дарга,
Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал

Дэлхий дахинд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгаль орчны доройтол, байгалийн гамшигт үзэгдлүүд нэмэгдэж хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчныг хангахад олон сорилт тулгарч байна. Монгол орны хувьд жилийн дундаж температур дэлхийн дунджаас 2.5 дахин эрчимтэйгээр нэмэгдэж буй үзүүлэлттэй байгаагаас гадна нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарлаар дэлхийд тэргүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах санаачилгад хувийн хэвшил, тэр дундаа банк, санхүүгийн салбар сүүлийн 10 гаруй жил манлайлж, идэвх санаачилга гаргаж, үүнийгээ ажил хэрэг болгож ирсэн. Монголын банкны холбоо, арилжааны банкуудын зүгээс 2013 онд Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг санаачилж, банкны салбарт хэрэгжүүлэн, өдгөө үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Ийнхүү энэ бүх санаачилга, эхлүүлсэн ажил төрийн бодлоготой уялдаж, өнгөрсөн 2022 онд Монголын банкны холбооноос санаачлан ойн салбарт санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох зорилгоор Тэрбум мод санг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Монголбанкны дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулж, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо менежментийг хариуцан, үйл ажиллагаа явуулж эхлээд нэг жил болжээ.

Энэ хугацаанд арилжааны банкууд нэгдэн банк хоорондын гүйлгээний шимтгэл

бүрээс 30 төгрөгийг төвлөрүүлж Тэрбум мод сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж ирлээ. Мөн ойжуулалт, мод тарих ажилд олон нийтийн оролцоог хангах, бүх нийтийн экологийн боловсролд хувь нэмэр оруулах зорилгоор гурван чиглэлд нийт 197 төслөөс 34 төслийг нээлттэй сонгон шалгаруулж, хэрэгжүүлж эхлэв. Дотоодын төдийгүй гадны байгууллагуудтай түншлэн, хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

Цаашид Тэрбум мод сангийн хувьд санхүүжилтийн олон төрлийн шийдлүүдийг нэвтрүүлж, Монгол орны ойн салбарын хөгжлийг шинэ түвшинд хүргэхэд хувь нэмрээ оруулж ажиллах болно.

Сангийн хандивлагчид, бодлогын дэмжигчид, дотоодын болон олон улсын түнш байгууллагууд, төсөл хэрэгжүүлэгчид, техникийн түр хорооны гишүүд та бүхний дэмжлэг, хамтын ажиллагааны үр дүнд Тэрбум мод сангийн ажлын гараа амжилттай эхлэж буйг онцлон, гүнээ талархъя. Та бүхэн нэг жилийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын дэлгэрэнгүй тайланг хүлээн авч, танилцана уу.

Бидний тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах зорилготойгоор 2021 оноос эхлэн орон даяар хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Тэрбум мод тарьж, арчлан, хамгаалж, ургуулах уг үндэсний хөдөлгөөний хүрээнд

“88.6 сая мод тарьж, арчлан, хамгаалж ургуулах амлалт өгснөөс банкны салбар 50 сая мод тарих амлалттай ажиллаж байна”

төрийн болон хувийн хэвшлийн томоохон аж ахуй нэгж, байгууллагууд бүгд өөрсдийн оруулах хувь нэмрийн талаар амлалтаа өгсөн юм.

Тус амлалтын хүрээнд банк, санхүүгийн салбар нийт 88.6 сая мод тарьж, арчлан, хамгаалж ургуулах амлалт өгснөөс банкны салбар 50 сая мод тарих амлалттай ажиллаж байна.

Банкны салбарын тус амлалтын хүрээнд Монголбанк, Монголын Банкны Холбооны гишүүн байгууллагуудын санаачилгаар

Тэрбум Мод Санг 2022 оны 3-р сард үүсгэн байгуулан Сангийн менежментийг Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо) хариуцан ажиллаж байна. Сангийн хувьд үйл ажиллагаа эхэлсэн анхны жил үндэс сууриа зөв тавих, олон улсын Сангуудын жишигт үйл ажиллагаагаа нийцүүлэх, хараат бус, нээлттэй, зөв засаглалын зарчмаар ажиллан, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох чиглэлээр баримталж буй бодлогын уялдааг дэмжихийн зэрэгцээ байгаль орчны салбарт санхүүгийн тогтвортой механизмыг бий болгохоор зорин ажиллаж байна.

Тэрбум Мод Сан нь байгаль орчны салбар, тэр дундаа ойн салбарын санхүүжилтийг төрөлжүүлэн зөвхөн төсөв эсхүл олон улсын зээл тусламжаар байгаль орчны төслүүд хэрэгждэг байсан жишгийг өөрчлөн дотоодоосоо буцалтгүй санхүүжилт болон салбарын онцлогт тохирсон шинэлэг санхүүжилтийн төрлийг нэмэгдүүлэхээр ажиллаж байгаагаараа онцлогтой.

Алсын хараа

Байгаль орчныг хамгаалах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, санхүүжилт босгон үндэсний хэмжээнд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг санг бий болгоно.

Эрхэм зорилго

Зөв газар, зөв модыг, зөв зорилгоор, зөв аргачлалаар тарьж, ойн салбарын тогтвортой санхүүжилтийн механизмыг бий болгоно.

Баримталж буй үндсэн зарчим:

Бодлогын уялдаа

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, бусад олон улсын & дотоодын уур амьсгалын өөрчлөлт болон цөлжилт, газрын доройтол, ойн салбарын зорилтуудыг дэмжих

Нээлттэй, хараат бус, зөв засаглал

Олон улсын байгаль хамгаалах сангуудын стандарт, сайн туршлагыг хэрэгжүүлж, Сангийн үйл ажиллагааг ил тод, хараат бус, зөв засаглалын зарчмын дагуу явуулах

Санхүүгийн тогтвортой механизм

Эдийн засгийн үр өгөөжтэй төслүүдийг түлхүү дэмжих, нэмэлт эх үүсвэрүүдээс санхүүжилт бүрдүүлэх, ойн салбарын тогтвортой санхүүжилтийн механизм бий болгох

Бидний үйл ажиллагаа тогтвортой хөгжлийн дараах зорилгуудад хувь нэмэр оруулж байна



**SUSTAINABLE
DEVELOPMENT GOALS**

Үйл ажиллагааны үндсэн чиглэл

Ой болон бусад экосистемийн тогтвортой ашиглалтыг дэмжих санхүүжилтийн хөтөлбөр

- Ойн салбарын нэмүү өртгийн сүлжээг дэмжих, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжих санхүүжилтийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх
- Ойн салбарт шинэлэг технологи, инновацыг нэвтрүүлэхэд дэмжих

Бичил төслийн санхүүжилтийн хөтөлбөр

- Олон нийтийн эзэмшлийн талбайд хэрэгжүүлэх ойн арчилгаа, нөхөн сэргээлт, цэцэрлэгжүүлэлтийн төслүүдийг санхүүжүүлэх
- Бодлогын болон шинжлэх ухааны судалгаа, инновац технологийн туршилтын төслүүдийг санхүүжүүлэх
- Тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх төслүүдийг санхүүжүүлэх

Чадавхжуулах хөтөлбөр

- Ойн салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх
- Ойн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудыг санхүү болон бизнесийн удирдлагын сургалтад хамруулан чадавхжуулах

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн гэж юу вэ?

Монгол орны ой нь мөнх цэвдэг, ус, чийгийг тогтоон барих, гадаргын усны горимыг зохицуулах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, ургамал, амьтны амьдрах таатай орчныг бүрдүүлэх зэрэг байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах хамгаалалтын өндөр ач холбогдол бүхий эмзэг тогтоцтой онцлог экосистем юм.

2020 оны байдлаар манай орны нийт нутаг дэвсгэрийн 76,9% буюу 120,3 сая га талбай бүхий нутаг цөлжилт, газрын доройтолд өртсөн болохыг тогтоогоод байна. Үүний 25% буюу 30 орчим сая га талбай цөлжилтийн хүчтэй ба нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна. Энэхүү судалгаагаар тал хээр, говийн бүсийн хур тунадас багатай Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр,

Төв зэрэг аймгууд цөлжилтөд хамгийн их өртөж газар нутгийн 50-95% нь цөлжилт газрын доройтолд өртсөн байна. Иймд МУ-ын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76-р чуулганаар “Тэрбумаар тоологдох мод ургуулах” санаачилгыг дэвшүүлсэн. Энэхүү санаачилга нь ойн санг 9%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилготой юм.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний зорилтууд:



Зорилт 1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг цогц удирдлага, зохицуулалтын нэгдсэн бодлогоор хангах эрх зүйн орчныг бий болгох;

Зорилт 2. Судалгаа, шинжилгээ хүний нөөцийг оновчтой бүрдүүлэх;

Зорилт 3. Модлог ургамлын үр, мөчрийн нөөц бүрдүүлэх, үрийн аж ахуйг хөгжүүлэх, мод үржүүлгийн газрыг төрөлжүүлэн, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, тарьц, суулгацаар хангах;

Зорилт 4. Ойн хомсдол, доройтлыг бууруулан, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх;

Зорилт 5. Цөлжилт, газрын доройтол, шороон шуурганы эх үүсвэрийг бууруулах, элсний нүүлтийг сааруулах;


Зорилт 6. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилттой уялдуулан төрөлжсөн агро-ойн аж ахуйг техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан байгуулах, жимс жимсгэнийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах замаар хөрсний элэгдлээс хамгаалж, хүнсний хангамжийг сайжруулах, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэх;

Зорилт 7. Гол мөрний урсац бүрэлдэх эх, татам, булаг шанд орчмыг ойжуулах замаар цэвдэг болон усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, бохирдол, хомсдолыг бууруулах;

Зорилт 8. Төв суурин газрын ногоон байгууламж, өрхийн жимс, жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх замаар агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, эрүүл амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх;

Зорилт 9. Авто зам, төмөр замын дагуу тэжээлийн таримал бүхий хамгаалалтын ойн зурвас байгуулах, ногоон дэд бүтцийн сүлжээг бий болгох, хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах;

Сангийн бүтэц, зохион байгуулалт



САНГИЙН САНААЧЛАГЧ, ХАНДИВЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД



БОДЛОГЫН ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн (2023 оны байдлаар)



З. Шагдарсүрэн
Тэрбум мод сангийн
Удирдах зөвлөлийн
дарга



Э. Анар
Удирдах зөвлөлийн
гишүүн, Монголбанкны
Төлбөр тооцооны
газрын Захирал



Б. Мэдрээ
Удирдах зөвлөлийн
гишүүн, Монголын
банкны холбооны
Ерөнхийлөгч



Р. Мөнхтуяа
Удирдах зөвлөлийн
гишүүн, Хаан банкны
Гүйцэтгэх захирал



О. Орхон
Удирдах зөвлөлийн
гишүүн, Худалдаа
хөгжлийн банкны
Гүйцэтгэх захирал



Б. Үүрцайхбаатар
Удирдах зөвлөлийн
гишүүн, Капитрон
банкны Гүйцэтгэх
захирал



О. Энхтуяа
Удирдах зөвлөлийн
гишүүн, Дэ Нэйче
Консерванси
байгууллагын зөвлөх

Ажлын албаны бүрэлдэхүүн



Э. Номиндарь
Гүйцэтгэх захирал



А. Болор
Зохицуулагч



Б. Арьяасүрэн
Гадаад харилцаа,
хамтын ажиллагаа
хариуцсан менежер



Л. Отгон-Аюуш
Нягтлан бодогч



Т. Маралгоо
Маркетингийн
менежер



Д. Энхлин
Төслийн менежер



Г. Янжинлхам
Төслийн мэргэжилтэн

Хяналтын хорооны бүрэлдэхүүн



А. Одонбаатар
Хяналтын хорооны
дарга, Голомт банкны
ерөнхий аудитор



Д. Ган - Очир
Хяналтын хорооны
гишүүн, Монголбанкны
Ерөнхий эдийн засагч



Д. Энхбаатар
Хяналтын хорооны
гишүүн, Хаан банкны
эрсдэл хариуцсан дэд
захирал

Техникийн түр хороо

Техникийн түр хороо нь Сангийн ажлын алба болон Удирдах зөвлөлд шийдвэр гаргахад мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж, дэмжлэг үзүүлэх зорилготой бүтэц бөгөөд тус бүтцийг төсөл сонгон шалгаруулалтын чиглэл тус бүрд зориулан түр байдлаар байгуулдаг. Техникийн түр хорооны хараат бус байдлыг хангах үүднээс гишүүдийг тогтмол шинэчлэн хороог байгуулах ба Техникийн түр хороонд ажиллах сонирхолтой мэргэжилтнүүдийн хүсэлтийг нээлттэй болон хаалттай байдлаар хүлээн авч Удирдах зөвлөлд танилцуулан, бүрэлдэхүүнийг тухайн төсөл сонгон шалгаруулалтын чиглэлд нийцүүлэн батлуулдаг.

Техникийн түр хорооны чиг үүргийн хувьд төслийн нээлттэй сонгон шалгаруулалтын хүрээнд хүлээн авсан нийт төслүүдэд техникийн, мэргэжлийн үнэлэлт дүгнэлт хийн 2-3 удаагийн ярилцлагыг зохион байгуулж, төслийн газар дээрх хяналт-үнэлгээг хийх, түүнийг үндэслэн мэргэжлийн хараат бус дүгнэлт гарган Сангийн ажлын алба болон Удирдах зөвлөлийг үнэн бодит мэдээлэл, дүгнэлтээр хангах зорилготой бүтэц гэдгээрээ онц ач холбогдолтой юм.

Техникийн түр хороо нь дотроо санхүү хөрөнгө оруулалтын, шинжлэх ухаан судлаачдын, маркетинг контент хөгжүүлэлтийн гэх мэт төрөл бүрийн чиглэлээс бүрдэх боломжтой.

Зөвлөх хороо

Зөвлөх хорооны гишүүд нь Сангийн зорилго зорилтыг биелүүлэхэд чиглэсэн зөвлөмж өгч ажиллах ба ингэхдээ Сангийн стратегийг үнэлж дүгнэх, бодлогын өөрчлөлтийн талаар зөвлөх, зорилтыг хэрэгжүүлэх алхмуудыг хэмжих, нөлөөллийг тодорхойлох зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ. Тус хороонд хөндлөнгийн байгаль орчны зөвлөх, санхүү хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд зэрэг олон улсын болон дотоодын төлөөллүүд байж болно.

Сангийн үйл явдлын товчоон

Үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд:

2022.03.30

“Ногоон санхүүжилт-Бүс нутгийн чуулган”-ы үеэр Банк, санхүүгийн салбарын дэмжлэгээр “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг дэмжих Санг үүсгэн байгуулах санаачилгыг үүсгэн байгуулав.



2022.05.01

Санаачлагч банкнуудаас Санд хандив цуглаж эхлэв.

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлээс **30₮**-ийг Санд төвлөрүүлж, Сангийн санхүүжилт эхлэв.

2022. 08-09

Сангийн анхны төслийн сонгон шалгаруулалттай холбоотой судалгааг хийж, гадна дотнын зөвлөхүүдтэй уулзаж санал солилцов.

- Салбарын мэргэжлийн байгууллагууд, хамтрагч, дэмжигч, хандивлагч байгууллагуудын төлөөллүүдээс төсөл сонгон шалгаруулах удирдамж дээр санал авав. Үүнд: ЕТГ, БОАЖЯ, Ойн газар, банкнуудын төлөөлөл
- Ойн салбарт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулав.
- Ойн салбарын мэргэжилтнүүдтэй хамтарсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, сангийн үйл ажиллагааны чиглэл дээр санал авав.
- Олон улсын итгэлцлийн сангуудын жишгээр төсөл сонгон шалгаруулалтын процессыг төлөвлөв

Канадын Засгийн газраас хэрэгжүүлж буй 2 тэрбум мод хөтөлбөрийг хариуцаж буй Байгалийн нөөцийн яамны мэргэжилтнүүдтэй цахимаар уулзаж, техникийн зөвлөгөө тусламжийг авав.

2022. 09

Тэрбум мод сангийн лого, өнгө төрхийг тодорхойлж, батлуулав.

2022.10.14

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн өдөрлөгт оролцож Тэрбум Мод Сангийн үйл ажиллагааны талаар МУ-ын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мод үржүүлэгчдийн төлөөлөлд мэдээлэл өгч санал солилцов.

Анхны төсөл сонгон шалгаруулах нээлттэй удирдамжийг олон нийтэд зарлаж, төсөл хүлээн авч эхлэв.



Сангийн үйл явдлын товчоон

Үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд:

2022.11.10

Тэрбум Мод Сангийн албан ёсны нээлтийн арга хэмжээг нийт хандивлагч, дэмжигч, хамтрагч байгууллагуудын хүрээнд зохион байгуулав. Нээлтийн арга хэмжээний үеэр БОАЖЯ, БШУЯ, Нийслэл Улаанбаатар хоттой хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэн хамтын ажиллагааг албажуулав.



“Хувийн хэвшлийн санаачилга, санхүүжилтийн эх үүсвэрээр байгаль орчныг хамгаалах, ойн салбарыг дэмжих Сан байгуулагдсанд талархалтай байна. Мөн эхний жилийн төслийн нээлттэй сонгон шалгаруулалт олон нийтийн экологийн боловсролыг дэмжих чиглэлийг хамруулсан нь зөв зүйтэй ажил гэж харж байгаа бөгөөд юун түрүүнд олон нийтийн тархинд мод тарих ажлыг эхлүүлэх нь чухал юм.”

БШУ-ы сайд Л. Энх-Амгалан

2023.03.27

Монгол-Солонгосын хамтарсан “Ногоон Хэрэм” төсөлтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Санамж бичгийн хүрээнд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний зорилго болох уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах ажлын хүрээнд ойжуулалт, мод үржүүлэг, ойн тогтвортой менежмент зэрэг чиглэлүүдэд хамтран ажиллаж, туршлага солилцох болов.



2023.03.29

НҮБХХ-ийн **BIOFIN II** төслийн санхүүжилттэй техник туслалцааны ажлыг эхлүүлэв.

Үүнд:

- 3 төрлийн вэбсайт болон веб систем хийж гүйцэтгэх ажлын хүрээнд Тэрбум мод сангийн вэбсайтыг хөгжүүлэх ажил хэрэгжиж байна.
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний санхүүжилтийг мөшгөх ажлын хүрээнд Сангийн грант олгох дунд хугацааны хөтөлбөрийн баримт бичгийг боловсруулах ажил хэрэгжиж байна.



2023.05.12

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “Ногоон хэрэм” төслийн 3-р шатны үйл ажиллагаа болох Хотын ойг дэмжихээр Монгол-Солонгосын “Найрамдлын цэцэрлэгт хүрээлэн”-д мод тарих арга хэмжээг хамтран зохион байгуулав.



Сангийн үйл явдлын товчоон

Үйл ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд:

2023.05.16

Бүх нийтээр мод тарих өдрүүдийг тохиолдуулан Хүн бүр байгаль хамгаалагч аяны хүрээнд Миний клуб ТББ-ын сайн дурын оюутан залуучуудтай хамтран мод тарив. Үүнд:



- Бүх нийтээр мод тарих өдрүүдийг тохиолдуулан 230 орчим оюутан залуус цуглан мод тарих аргачлал болоод Тайваний мод усалгааны эко хувингийн ашиг тусын талаар мэдэж авсан юм. Залуучууд мод тарих практик мэдлэгтэй болж Хязгааргүй байгаль сан ТББ-тай хамтран Цонжин Болдогт 800 орчим мод тарив.
- Бэлхийн гүнжийн булагт 800 мод тарьж мод үржүүлгийн талбайд ажиллан, дауны холбооны кофе шопт мод тарилаа.
- Ахлах, дунд сургуулийн хүүхдүүд, оюутан залуустай хамтдаа модны тарьц бэлтгэх ажлуудыг хийсэн юм.

2023.05.27

“Тэрбум Мод Үндэсний хөдөлгөөний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээ” Баруун бүсийн 3 аймгийг хамарсан зөвлөлдөх уулзалтад оролцож Сангийн талаар мэдээллийг хүргэв.



2023.05.30-31

“Банкны салбарын хөгжил” хакатоныг Монголын банкны холбоо, ТоС Холбоо болон Банк санхүүгийн академитай хамтран зохион байгуулав. Уг хакатоны хүрээнд Хас банкны баг Тэрбум мод сангийн хандивын мэдээллийг бүх банкнуудын аппликейшн дээр байршуулах шийдлийг эрэлхийлж судалгааг танилцуулав.



2023. 06

Сангийн анхны сонгон шалгаруулалтад тэнцсэн 34 төслийг сонгон шалгаруулж, 1.3 тэрбум төгрөгийг олгох болсныг олон нийтэд зарлаж, төслүүдэд батламж гардуулав.

Анхны 34 төслүүдтэй гэрээ байгуулж, хэрэгжилтийг эхлэв.



2022–2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ



2022–2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

1. Төсөл сонгон шалгаруулах удирдамж зарлах

2022.10.18

Тэрбум Мод Сангаас төслийн хамгийн анхны төслийн нээлттэй сонгон шалгаруулалтын талаар олон нийтэд мэдээлэл өгөх хэвлэлийн бага хурал зохион байгуулав.

Төсөл сонгон шалгаруулах чиглэл

Нийт төслийн 50%

Нийт санхүүжилтийн 33%

Чиглэл 1: Нийслэлийн төрийн өмчит цэцэрлэг, сургуулийн ногоон байгууламжийн төслүүд

30 хүртэлх сая төгрөгийг
20 төсөлд олгоно

Нийт 600 сая төгрөг

Нийт төслийн 25%

Нийт санхүүжилтийн 56%

Чиглэл 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулах, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

50-100 сая төгрөг,
10 хүртэлх төсөлд олгоно

Нийт 1 тэрбум төгрөг

Нийт төслийн 25%

Нийт санхүүжилтийн 11%

Чиглэл 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

5-20 сая төгрөг,
10 хүртэлх төсөлд олгоно

Нийт 200 сая төгрөг

Төсөлд тавигдах үндсэн шалгуур:

1. Төслийн үр дүн, үр нөлөө, хамрах хүрээ
2. Төслийн үндэслэл, Сангаас санхүүжилт хүсэж буй шалтгаан
3. Төсөл хэрэгжүүлэгчийн хүний нөөц, туршлага
4. Төсөл хэрэгжүүлэгчийн газрын нөхцөл байдал, аргачлал
5. Хамтын ажиллагаа
6. Шинэлэг санаа, технологи
7. Төсвийн үндэслэл, тооцоо
8. Арчилгаа, хяналт, тайлагналын төлөвлөгөө
9. Төслийн тогтвортой үргэлжлэх, түгээн дэлгэрүүлэх боломж



2022–2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

1. Төсөл сонгон шалгаруулах удирдамж зарлах

2022.10

Төсөл ирүүлэх сонирхолтой байгууллагуудад зориулан хоёр удаагийн мэдээлэл өгөх цахим уулзалт зохион байгуулж 100 гаруй хүнд мэдээлэл өгөв.

2022.11.15

Төсөлд оролцох сонирхолтой байгууллагуудын төслийн товч санал дээр зөвлөгөө өгөх ажлыг эхлүүлэв.

2022.12.05-07

Тэрбум Мод Сангийн ажлын алба Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон аймгуудад ажиллаж төсөл сонгон шалгаруулалтын мэдээллийг олон нийтэд хүргэх, оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд иргэд болон байгууллагуудад Сангийн үйл ажиллагаа болон төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэв.




2022-2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

2. Төслийн материалууд хүлээн авах

2022.12.30 хүртэл

2022-2023 төслийн нээлттэй сонгон шалгаруулалтын хүрээнд нийт **197 төслийн материалыг** хүлээн авч дуусав.


Хүлээн авсан төслүүдийн ерөнхий мэдээлэл



	Чиглэл 2	Чиглэл 3
Улаанбаатар	19	18
Орон нутаг	81	44

Чиглэл 1

Нийслэлийн төрийн өмчит цэцэрлэг, сургуулийн ногоон байгууламжийн төслүүд



Дүүрэг	Тоо
Багануур	1
Багахангай	0
Баянгол	4
Баянзүрх	9
Налайх	3
Сонгинохайрхан	5
Сүхбаатар	4
Хан-Уул	6
Чингэлтэй	3


Чиглэл 2

Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулах, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

Аймаг тус бүрээс хүлээн авсан төслийн мэдээлэл

Аймаг/Хот

Улаанбаатар	19	Завхан	2
Архангай	3	Орхон	2
Баян-Өлгий	3	Өвөрхангай	6
Баянхонгор	7	Өмнөговь	1
Булган	8	Сүхбаатар	2
Говь-Алтай	1	Сэлэнгэ	7
Говьсүмбэр	2	Төв	9
Дархан-Уул	9	Увс	6
Дорноговь	1	Ховд	6
Дорнод	1	Хөвсгөл	1
Дундговь	1	Хэнтий	3




Чиглэл 3:

Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд



Сургалт, хөтөлбөр боловсруулах	24
Олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх	17
Бүх төрлийг хамарсан	11
Медиа, контент хөгжүүлэх	9
Бусад	1



2022–2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

3. Ажлын албаны урьдчилсан хяналт, үнэлгээ хийх

2023.01 сар

Нийт ирүүлсэн төслийн урьдчилсан шатны үнэлгээ, материалын бүрдэл шалгах ажлыг эхлүүлэв.

Техникийн түр хорооны гишүүдийг Удирдах зөвлөлд танилцуулж, гишүүдийг батлав. Тус хорооны бүрэлдэхүүнд ойн аж ахуй, ойн нөхөн сэргээлт, агро-ойн аж ахуй, ногоон байгууламжийн чиглэлээр олон жил ажилласан туршлагатай 14 мэргэжилтэн ажиллаж хандивлагч банкуудаас санхүү, эдийн засаг, ногоон санхүүжилт, эрсдэлийн чиглэлээр мэргэшсэн газар хэлтсийн захирал 7 гишүүн мөн Монголын банкны холбооны мэргэжлийн зөвлөлөөс 2 мэргэжилтэн, Сангийн ажлын албанаас 1 төлөөлөл **НИЙТ 24 гишүүнтэйгээр байгуулагдав.**

4. Техникийн хорооны үнэлгээ хийх, зөвлөмж гаргах

2023.02.01-27

Төслүүдийн техникийн хорооны үнэлгээний ажил эхлэв.

2023.02.27-3.10

Техникийн хорооны үнэлгээгээр өндөр эрэмбэлэгдсэн төслүүдтэй техникийн хороо ярилцлага зохион байгуулав.

2023.03.10-04.18

Техникийн хорооноос ирүүлсэн нэмэлт асуулт, тодруулгын дагуу төслүүд нэмэлт мэдээллийг ирүүлэв.

Техникийн хорооны бүрэлдэхүүн нийт 2 сарын хугацаанд **100 гаруй төсөлд 3 шатлалаар техникийн үнэлгээ хийв.**

Үүнд төслийн материалд үндэслэн техникийн болон санхүү эдийн засгийг үндэслэл хийж түүний дараагаар төслүүдтэй цахим уулзалт зохион байгуулан төслийн материал дээр тодруулга аван дараагаар нь төсөл хэрэгжих газар дээр очин хяналт-үнэлгээ хийж төсөл хэрэгжүүлэгчийн нөөц чадавх, туршлагад үнэлгээ өгсөн юм.

Тус дүгнэлтийг үндэслэн Удирдах зөвлөлийн гишүүд төсөл хэрэгжүүлэгч нартай сүүлийн шатны ярилцлагыг хийж төслүүдийг баталсан юм.

2022–2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

5. Төсөл хэрэгжих газар дээрх шалгалт, ярилцлага

2023.03.10-04.18

Төслүүдийн газар дээрх
хяналт-үнэлгээний
ажлыг техникийн
хорооны төлөөллийн
хамт зохион байгуулж
**Улаанбаатар хот болон
8 аймагт ажиллан 20
гаруй төслийн газартай
танилцав.**


6. Удирдах зөвлөлд шалгарсан төслүүдийг танилцуулан батлах

2023.04.19

Төслүүдийн үнэлгээг
нэгтгэж удирдах зөвлөлийн
хурлаар танилцуулав. Өндөр
эрэмбэлэгдсэн төслүүдтэй
Удирдах зөвлөлийн гишүүд
уулзаж, сүүлийн шатны
ярилцлага, үнэлгээг хийж
төслүүдийг батлав.

7. Төслүүдэд мэдэгдэж, нөхцөл тохирох

8. Санхүүжилтийн гэрээ байгуулах



2022–2023 ОНЫ ТӨСЛИЙН НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

9. Шалгарсан төслүүдийг олон нийтэд зарлах

2023.05.18

2022-2023 оны төслийн нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнд шалгарсан **34** төслийг олон нийтэд нээлттэй танилцуулан, төслүүдийг батламжилж, төслүүдийн гэрээг үзэглэв.



2023.05.22

Төслүүдэд эхний ээлжийн санхүүжилтийг олгон төслийн хэрэгжилтийг эхлүүлэв.



Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд бүхий л салбар, аж ахуй нэгжүүд нэгдэж байгаа бөгөөд үүн дундаас нэгэн бодит санаачлагыг банк санхүүгийн салбар түүчээлэн эхлүүлж Тэрбум мод санг байгуулан, иргэдийн мод тарих хандлагыг өөрчлөх, соён гэгээрүүлэх болоод бодитоор мод тарих ойжуулах ажилд нэгдэж буйд талархалтай байна.

Цаашид олон улсын карбоны зах зээлд орох ажилд зөв механизм, оновчтой шийдлийг гаргаж тэргүүлж ажиллаасай гэж хүсэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга **Я.Содбаатар**

Монголын арилжааны банкууд санаачлаад Тэрбум мод сан гэдэг хөтөлбөрийг гаргасан. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Дэлхий нийтэд амласан амлалтыг биелүүлэхэд бидний зүгээс хүчин чармайлтаа нэгтгэж байгаа үйл явц юм.

Цаашид мод тарьж ургуулах урт хугацааны буюу дор хаяж 3-10 жил үргэлжилдэг уг салбар ногоон зээлийн шинэ бүтээгдэхүүнүүдийг гарган төсөл хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуй нэгжүүдийг дэмжих ажлуудыг төлөвлөж байна.

Хаан банкны Гүйцэтгэх захирал **Р. Мөнхтуяа**



“Тэрбум мод сангийн хамт олон төслөө зарлаад олон нийтэд мэдээлэл хүргэж эхлэх үеэс л аль болох салбартаа олон жилийн турш бодитой ажлуудыг итгэл сэтгэл, хүсэл тэмүүллээрээ хийж байгаа хүмүүсийг дэмжиж, мод тарих ажлыг бүх нийтийн үйлс болгон төслүүдээ амжилттай хэрэгжүүлж хүүхэд залуусынхаа оюун тархинд модны үр соёолуулах гэсэн чин сэтгэлээр хандаж байгаа нь харагдаж байсан.

Мэргэжлийн өндөр түвшинд ч ажилладаг хамт олон байна. Монголд маань зөв зүйлийг, зөв хүнийг, зөв ажлыг дэмжих соёл тогтож байгаа юм байна даа гэсэн итгэл үнэмшил энэ хамт олноос олж авлаа.”

МУИС-ийн Экологийн боловсролын төвийн ахлах мэргэжилтэн **Р. Сүнжидмаа**

“Тэрбум Мод Сангийн санхүүжилтээр Нийслэлийн ЕБ-н зургаан сургуулийн гадна орчинд мод зүлэг тарьж ногооруулав.

Сургуулийн орчин хамгийн эрүүл, цэвэрхэн, эко байх ёстой. Тохилог ногоон орчинд хүүхэд сайн сурдаг.”

Люксландшафт ХХК-ий Удирдах зөвлөлийн дарга **Ц. Түмэнбаяр**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг урагшлуулах нэг гол хүчин зүйл нь банк санхүүгийн байгууллагаас санаачлан үүсгэн байгуулсан Тэрбум мод сан байлаа. Төслийн сонгон шалгаруулалтын олон удаагийн ярилцлага, бичиг баримтыг сайжруулах болон газар дээрх хяналт шалгалт зэрэг олон үе шатыг давах явцад бидэнд ч мөн сурч мэдэх зүйл их гарч байлаа. Энэ бүхний ард төсөл маань шалгараад хэрэгжүүлэх болсондоо баяртай байна, уг нээлтийн арга хэмжээ ч мөн мэргэжлийн хүмүүс бидний урмыг бадрааж улам их хичээх хэрэгтэйг сануулж байна.

ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн захирал **А. Буянбаатар**

Тэрбум мод санг байгуулсан Монголын банкны холбоо болон арилжааны бүх банкууддаа талархаж буйгаа илэрхийлмээр байна. Байгаль орчны салбарт үйл ажиллагаа явуулж буй ТББ болон иргэний нийгмийн байгууллагууд өмнө нь зөвхөн гаднаас санхүүжилт авч төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байсан бол одоо дотоодоосоо ч санхүүжилт авах боломжтой жишиг сан гарч ирж буйд баяртай байна.

Шалгарсан төслийнхөө хүрээнд Эзэнтэй мод гэдэг ойлголтыг өөрсдийн сургалт, аргазүй дээр үндэслэн хэрэгжүүлэхээр болоод байна. Мөн бидний төсөл Тэрбум мод сангийн анхны санхүүжилт тул бид бас хариуцлагатайгаар төслөө амжилттай хэрэгжүүлж, зөв шанг нь татаж зөв эхлүүлж чадсанаар дараа дараагийн олон сайхан төслүүд хэрэгжих боломжтой болно.

Public Lab Mongolia ТББ-ын гүйцэтгэх захирал **С. Эрдэнэцогт**



Энэ жил бид



1.3 тэрбум
төгрөгийн буцалтгүй
санхүүжилт



34 төсөл
Чиглэл 1 - 20 төсөл;
Чиглэл 2 - 7 төсөл;
Чиглэл 3 - 7 төсөл



800'000
хүнд экологийн
боловсрол олгох



20'000+
м2 ногоон
байгууламж



105'000+
Мод



37+ га
ойжуулалт, ойн
нөхөн сэргээлт



72+
ажлын байр



3+
шинэ
технологи
турших



18'355
хүүхдэд
ногоон орчин


Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

ЧИГЛЭЛ 1: Нийслэлийн төрийн өмчит цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуулийн ногоон байгууламж

Энэхүү чиглэлд нийслэлийн төрийн өмчит 11 цэцэрлэг, 9 сургууль шалгарсан бөгөөд ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажил болон гурван жилийн турш арчилгаа хамгааллын мэргэжлийн зөвлөгөөг өгч ажиллахаар Тансаг Ландшафт, УБТ Гарден, Люкс Ландшафт байгууллагууд сонгогдов.

Уг чиглэлийн хүрээнд хүүхэд залуучуудын сурах орчинг эрүүл болгож, багш, сурган хүмүүжүүлэгч, сурагч, эцэг эхчүүдийн дунд мод тарих, арчилж хамгаалах аргачлал, ач холбогдлын талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, цаашид үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломжтой загвар бий болох юм.

Чиглэл 1-д шалгарсан 30 төслийн хэрэгжилт - 80%



Уг гүйцэтгэлийн хүрээнд:

- 15352 хүүхдэд ногоон орчин бүрдүүлээ
- 2304 гоёлын мод
- 9676 хайлаас - ногоон хашлага
- 6573 м.к зүлэгжүүлэлт
- 422 м.к цэцгийн мандал



№	Дүүрэг	Байгууллагын нэр	Тарьсан модны тоо	Зүлэгжүүлсэн талбайн хэмжээ, м2	Эрүүл ногоон орчинд суралцах хүүхдийн тоо
1	Баянгол	"Сэтгэмж" цогцолбор сургууль	786	500	1220
2	Баянгол	19-р сургууль	1351	175	1672
3	Баянгол	51-р сургууль	1463	700	2085
4	Баянгол	94-р цэцэрлэг	911	500	254
5	Сүхбаатар	159-р сургууль	705	500	1800
6	Сүхбаатар	281-р цэцэрлэг	612	435	280
7	Баянзүрх	69-р сургууль	637	485	3687
8	Баянзүрх	85-р сургууль	681	472	996
9	Баянзүрх	61-р цэцэрлэг	Гадаа туршилтын талбай	300	600
10	Баянзүрх	289-р цэцэрлэг	700	396	614
11	Баянзүрх	301-р цэцэрлэг	632	573	522
12	Сонгинохайрхан	112-р цэцэрлэг	700	300	386
13	Сонгинохайрхан	119-р цэцэрлэг	702	300	467
14	Сонгинохайрхан	118-р цэцэрлэг	700	300	466
15	Сонгинохайрхан	196-р цэцэрлэг	700	329	188
16	Хан-Уул	190-р цэцэрлэг	700	308	115
17	Баянзүрх	Монгол Тэмүүлэл сургууль	700*	300*	208
18	Налайх	103-р сургууль	700*	300*	722
19	Чингэлтэй	43-р цэцэрлэг	700*	300*	253
20	Хан-Уул	34-р сургууль	700*	300*	2848
Нийт			14,780	7,773	19,383

*2023 оны намар болон 2024 оны хавар хийхээр төлөвлөж байна.


Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

**ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт,
ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд**

Байршил: **Улаанбаатар**
Нэр: ХААИС - Агроэколгийн сургууль
Талбай: **15га**
Тарих модны тоо: **37,500**

Байршил: **Улаанбаатар**
Нэр: ШУТИС - ОССХ
Талбай: **5га**
Тарих модны тоо: **12,000**

Байршил: **Улаанбаатар**
Нэр: JCI Eco ТББ
Талбай: **5га**
Тарих модны тоо: **5,000**



Байршил: **Өмнөговь**
Нэр: Жаргалантын итгэлцэл хоршоо
Талбай: **1га**
Тарих модны тоо: **5,000**

Байршил: **Өвөрхангай**
Нэр: Сумт ойн нөхөрлөл
Талбай: **8га**
Тарих модны тоо: **20,000**

Байршил: **Баянхонгор**
Нэр: Эрдэнэт номгоны хишиг хоршоо
Талбай: **2га**
Тарих модны тоо: **10,498**

Байршил: **Ховд**
Нэр: Түмэн модот хаалга ТББ
Талбай: **2га**
Тарих модны тоо: **2,580**

Нийт төсөл хэрэгжих хугацаанд

38 га 92,578 мод

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



**“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД
ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖТАЙ
ОЙ УРГУУЛАХ ТУРШИЛТ
СУДАЛГАА”**

Төсөл хэрэгжүүлэгч:
ШУТИС-ийн Ой модны
сургалт судалгааны
хүрээлэн



Төсөл хэрэгжих байршил
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Улиастайн ам

Төслийн товч мэдээлэл:
Улиастайн амны салаа Байшинтын амны 2008 онд түймэрт өртөж доройтсон ойн 5 га газарт хуш болон шинэсний холимог ой ургуулж **10,000** гаруй мод тарих бөгөөд холбогдох судалгааг гүйцэтгэнэ.
Уг төслийг хэрэгжүүлэхэд үр түүхээс эхлэн бойжуулж, тарилт хийн таван жилийн турш арчилгаа хамгаалалтыг хийнэ.
Төслийг хэрэгжүүлэх явцад органик бортогоны зохистой найрлага, органик бортого үйлдвэрлэх механик ажиллагаатай төхөөрөмж, бортоготой тарьц зөөх ойжуулагчийн үүргэвч гэсэн шинэ бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлнэ. Туршилтын ажлууд амжилттай болвол олон нийтэд түгээн дэлгэрүүлэх боломж бүрдэхээс гадна, ойн анги, ойн нөхөрлөлдүү авч хэрэгжүүлэхэд тохиромжтой, бага өртөгтэй ойжуулалтын багц бүтээгдэхүүн бий болох юм. Мөн гурван төрлийн эрдэм шинжилгээний өгүүлийг нийтэлж хэвлүүлэх юм.



ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжтай ой ургуулах туршилт судалгаа”

ШУТИС-ийн Ой модны сургалт судалгааны хүрээлэн



Санхүүжилт
Сангаас **100** сая
Хамтын **25** сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023 - 2025



Төслийн явц:
30%



Тарих модны тоо:
10,000



Нөхөн сэргээх талбай:
5 га



Ажлын байр:
30



Бусад:
шинээр турших 3 төрлийн
техник технологи

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“10000 МОДТОЙ БОЛОХОД ИРГЭДИЙН ОРЛОЦООТОЙ 2580 МОД ТАРЬЖ АМЬД НОГООН ХААЛГА БИЙ БОЛГОХ”

Төсөл хэрэгжүүлэгч:
Түмэн модот хаалга НҮТББ

Төсөл хэрэгжих байршил
Ховд аймаг, Ховд хот

Төслийн товч мэдээлэл:
Ховд хот руу орох төв зам дагуу амьд ногоон хаалга бий болгох зорилгоор жолооч нар сайн дураар нэгдэн 8000 гаруй мод тарьсан бөгөөд үүнийг бүтэн гүйцээхийн тулд 2 га газарт нэмж 2,580 мод тарьж, арчилж ургуулах юм.
Уг төсөл нь олон нийтийн оролцоог хангасан сайн жишиг төсөл болж бусад аймаг хотуудад дэлгэрүүлэх боломжтой гэдгээрээ онцлогтой юм.
Энэ төсөл нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний авто зам дагуу хамгаалалтын ойн зурвас байгуулж хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах зорилгод нийцэж байгаа бөгөөд уг тарьсан моднууд нь үр болон мөчрийн эх мод болж, үүнээс модны үржүүлэг хийн эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.

10.000 МОД
ОЛОН ЯСТНЫ УГТАХ ХААЛГА

ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

“10000 модтой болоход иргэдийн оролцоотой 2580 мод тарьж Амьд ногоон хаалга бий болгох”

Түмэн модот хаалга НҮТББ | Ховд аймаг, Ховд хот



Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



“8 ГА ТАЛБАЙД 20,000 ШИНЭС МОДНЫ ОЙЖУУЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛ ХИЙХ ТӨСӨЛ”

Төсөл хэрэгжүүлэгч:
Сумт ойн нөхөрлөл



Их сумт
хайрхан ХХК



Төсөл хэрэгжих байршил
Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум

Төслийн товч мэдээлэл:

Өвөрхангай аймаг Бат-Өлзий сумын 4-р багийн нутаг дэвсгэр Хойд агуутын “Зуухны-Ар” гэдэг тусгай хамгаалалттай газар нь хөнөөлт шавьж, хууль бус мод бэлтгэлийн улмаас ойн доройтолд орж унанга хаягдал, уг ёзоор болж үлдсэн газар юм. Иймээс энэхүү газрын 8 га талбайг цэвэрлэж, хашаажуулан **20,000** ширхэг 3-ээс дээш настай шинэсний суулгацыг тарьж ойжуулалт хийнэ.

Ойн нөхөрлөл нь ойжуулалтын мэргэжлийн байгууллага, сум дундын ойн анги, Орхоны хөндийн байгалийн цогцолборт тусгай хамгаалалттай газрын захиргаа болон нутгийн иргэдтэй хамтран уг төслийг хэрэгжүүлснээр олон талт хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог бүрэн хангаж чадаж байгаа юм. Цаашдаа ойжуулалт хийх болоод тарьсан модоо арчилж ургуулах зөв мэдлэг мэдээллийг уг төсөлд гар бие оролцсон иргэд олж авах юм.




ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

“8 га талбайд 20,000 шинэс модны ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил хийх төсөл”

Сумт төгөл ойн нөхөрлөл | Өвөрхангай аймаг, Бат-Өлзий сум



Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



**“ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ АШИГЛАН
ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД
СУУРИЛСАН МОД ТАРИХ, МОД
ҮРЖҮҮЛЭГ ХИЙХ ТЕХНОЛОГИ
ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ”**

Төсөл хэрэгжүүлэгч:
ХААИС Агроэкологийн сургууль



ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ
Тогтвортой хөгжлийн төлөө
АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

Төсөл хэрэгжих байршил
Төв аймгийн Баянчандмань

Төслийн товч мэдээлэл:
Төслийн хүрээнд Канад улсын хүчилтөрөгчийн нанобөмбөлгийн технологийг мод үржүүлэг, ойжуулалтын ажилд туршиж тарьц суулгацын өсөлт, чанар, амьдралтын хувьд хэрхэн нөлөөлж буйг харьцуулан судлана. Канад болон Америкт хийсэн туршилтуудаас харахад модны ургалтыг 28%-иар нэмэгдүүлж, модны өвчлөх магадлалыг бууруулдаг, мөн жимсний модны жимслэх чадвар 9%-иар нэмэгдсэн эерэг эерэг үр дүнгүүд гарч байжээ.

Туршилт судалгааны ажил амжилттай болвол уг технологийг Монголд нутагшуулан хэрэглэх боломж бүрдэх бөгөөд үүнийг олон нийтэд түгээн дэлгэрүүлж, стандартын тарьц суулгацын тоог нэмэгдүүлж, уур амьсгалын тааламжгүй нөхцөлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх юм. Мөн төслийн үр дүнгээс гарсан **37,500 тарьц**, суулгацаар доройтсон ойг нөхөн сэргээх.




ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

“Дэвшилтэт технологи ашиглан олон нийтийн оролцоонд суурилсан мод тарих, мод үржүүлэг хийх технологи түгээн дэлгэрүүлэх нь”

ХААИС Агроэкологийн сургууль | Төв аймгийн Баянчандмань



Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“ЗАЛУУ ОЙ”

Төсөл хэрэгжүүлэгч:
JCI Монгол ТББ-ын JCI Эко салбар






Төсөл хэрэгжих байршил
Улаанбаатар хот, Дархан цаазат
Богдхан уулын Их тэнгэрийн зүүн ам

Төслийн товч мэдээлэл:
Тус байгууллага нь 2018 оноос хойш олон нийтийн оролцоотойгоор мод тарьж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд нэмж 6 төрлийн **6,000** суулгацыг тарьж ургуулахыг зорьж байна.
Тарьсан модоо арчилж ургуулах үйл явцад олон нийтийг өргөнөөр хамруулж, тэдэнд мод тарих арчлахын ач холбогдлыг ойлгуулах сургалт, мэдээ мэдээллийг тогтмол явуулах юм.

ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

Залуу ой

JCI Монгол ТББ-ын JCI Эко салбар



Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



“ОРГИЛ БУЛАГ”

Төсөл хэрэгжүүлэгч:
Жаргалантын итгэлцэл хоршоо



**Жаргалантын
Итгэлцэл Хоршоо**

Төсөл хэрэгжих байршил
Өмнөговь аймаг, Баяндалай сум

Төслийн товч мэдээлэл:

Уг хоршоо нь нарны панелаар ажилладаг гүн өрмийн худагтай бөгөөд гурван хүлэмжинд нарийн ногоо тарьж, хайлаас модыг үржүүлж эхэлсэн байна. Цаашид өөрсдийн аж ахуй бүхий 1 га газарт гурван төрлийн модыг салхины хамгаалалт бүхий зурвас болгон **5,000** мод тарьж ургуулна.





Ингэснээр уг төсөл говийн бусад бичил агро-ойн аж ахуй бий болгох жишиг төсөл болох бөгөөд цаашид байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд тогтвортой үргэлжлэх боломжтой. Тус хоршоо нь өмнө малын тэжээлийн ургамал тариалдаг байсан бөгөөд хоёр жилийн өмнө үерт автсанаар газар сэлгэн нүүж агро-ойн аж ахуйн жишгээр үйл ажиллагаагаа өргөжүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох шийдлийг эрэлхийлж буй юм.




ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

“Оргил булаг”

Жаргалантын итгэлцэл хоршоо



Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



“ХАЙРЫН ТӨГӨЛ”

Төсөл хэрэгжүүлэгч:
Эрдэнэт номгоны хишиг хоршоо





“ХАЙРЫН ТӨГӨЛ” ТӨСЛИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЕРӨНКИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих байршил
Баянхонгор аймгийн төвийн Түйн голын эрэг



Төслийн товч мэдээлэл:

Баянхонгор аймгийн төвийн Түйн голын эрэг дагуух талбайг иргэдийн амралт зугаалгын бүс болгохыг зорин ажиллаж байгаа бөгөөд тус талбайд 2 га газарт ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж, тарьсан мод ургамлаа цаашид тогтмол арчлан хамгаалах юм.

Төслийн хүрээнд **10,000** ширхэг хайлаасыг амьд ногоон хашлага болгон тарьж, хэлбэржүүлэх бөгөөд 498 ширхэг олон төрлийн гоёлын модыг тарьж ургуулах юм. Ингэснээр тухайн бүсийн тоосжилт, хуурайшилтыг бууруулахад хувь нэмэр оруулах бөгөөд иргэдийн амьдрах орчныг таатай болгох эерэг олон өөрчлөлтүүдийг бий болгоно. Мөн уг төслийг хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэн тогтмол ажлын байртай болох юм.



ЧИГЛЭЛ 2: Олон нийтийн оролцоонд суурилсан ойжуулалт, ойн нөхөн сэргээлт, мод тарих төслүүд

“Хайрын төгөл”

Эрдэнэт номгоны хишиг хоршоо



Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ



“АМЬД БАЙГАЛЬ АЛЬ Ч ЦАГТ - ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ”

Төсөл хэрэгжүүлэгч:
МУИС-ийн Экологийн боловсролын төв



Төслийн товч мэдээлэл:

Тус төвийн сургалтын хөтөлбөрт “**Ой модны үйлчилгээ**” гэсэн шинэ өртөөг байгуулах бөгөөд түүнтэй холбоотой танхимын тохижилтийг гүйцэтгэн, сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулна.


Мөн Экологийн боловсролын төвийн сургалт - аялалд хамрагдах боломжгүй алслагдмал дүүргийн **1,000** сурагчдыг оролцуулах юм. Уг төвийн өртөөгөөр аялсан хүүхдүүд байгалийг илүү ойроос мэдэрч, бодит үзүүлэн хэрэглэгдэхүүний тусламжтайгаар байгалийн зүй тогтлыг танин мэдэх ба байгалийг илүү сонирхон судалж, эх дэлхийтэйгээ зөв зохистой харьцаж, түүний баялгийг хайрлан хамгаалах сэдэлтэй болно.



ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Амьд байгаль аль ч цагт - экологийн боловсрол олгох сургалт”

МУИС-ийн Экологийн боловсролын төв



Санхүүжилт
Сангаас Хамтын
20 сая **20.7** сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023



Төслийн явц:
40%



Үр дүн

Шинэ сургалтын хөтөлбөр



Сургалтад хамрагдах сурагч

1,000

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

**“УЛААНБААТАР ТӨГӨЛ:
ИРГЭДИЙН ОРЛОЦООТОЙ
МОД ТАРИХ ТӨЛӨВЛӨЛТ”**

Төсөл хэрэгжүүлэгч:
Паблик Лаб Монголиа ТББ

Төслийн товч мэдээлэл:

Төслийн хүрээнд нээлттэй орон зайн өгөгдөл цуглуулах OpenStreetMap платформыг ашиглан оюутан залуус, иргэдийн оролцоотойгоор Улаанбаатар хотын гэр хорооллын мод, ногоон байгууламжийг зураглаж, цуглуулсан орон зайн өгөгдлийг холбогдох нэмэлт мэдээллээр баяжуулах замаар нэрийвчилсэн дүн шинжилгээ хийнэ. Жишээлбэл мод тарьсан, тариагүй байршлууд дахь үер болон хэт халууны (heatwave) эрсдэлийг тооцоолж харьцуулан харуулах боломжтой болох юм.

Дүн шинжилгээг олон нийтэд, сонирхолтой ойлгомжтой байдлаар дүрслэн харуулж, мод тарих, түүний давуу талыг түгээн таниулах замаар, ногоон үзэл санаа, чиг хандлагыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлж, хашаандаа мод тарьсан иргэдийн түүх, тэдгээрийн арга туршлагыг олон нийтэд түгээнэ. Мөн уг суурь судалгаан дээр үндэслэн нэг хороог сонгон авч иргэдийн оролцоотой мод тарих боломжит болон шаардлагатай байршлыг тогтоон төлөвлөлтийг хийнэ. Хаана, ямар мод тарих, хэрхэн арчлах зэрэг урт хугацааны төлөвлөлтийг холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан сайжруулах юм.

Паблик Лаб Монголиа ТББ
CULTIVATING HEALTHY ENVIRONMENT &
RESILIENT COMMUNITIES THROUGH OPEN DATA

Чиглэл 3


**“Улаанбаатар төгөл:
иргэдийн оролцоотой
мод тарих төлөвлөлт”**

Төсөл хэрэгжүүлэгч:
Паблик Лаб Монголиа ТББ

Тариулсан өдөр:
Улаанбаатар хот, 3 дүүргийн, 12

ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Улаанбаатар төгөл: иргэдийн оролцоотой мод тарих төлөвлөлт”
Паблик Лаб Монголиа ТББ



Санхүүжилт
Сангаас Хамтын
20 **17.8**
сая сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023



Төслийн явц:
40%



Үр дүн

УБ хотын гэр хороололд таригдсан байгаа модны зураглал, мод тарих боломжит байршил зэрэг суурь судалгаа гарна

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“ИЛБЭЧИН МОД”

Төсөл хэрэгжүүлэгч:
Марчаахай студи ТББ

Төслийн товч мэдээлэл:

Төслийн хүрээнд ойн салбарын мэргэжилтнүүдтэй хамтран **5-12** насны хүүхдэд зориулсан модны ач тус, түүнийг хэрхэн арчилж ургуулах талаар сонирхолтой нэг ангит анимейшн видео контент бүтээж, олон нийтэд түгээнэ.

Төслийн зорилго: 5-12 насны хүүхдэд зориулсан модны ач тус, түүнийг хэрхэн арчилж ургуулах талаар сонирхолтой нэг ангит анимейшн видео контент бүтээж, олон нийтэд түгээнэ.

Мэдээ олгох хүүхдийн кинотой.

Тоглоомоо сурацгааж, мэдлээ баталгана.


Боловсролд тэгш хүртээмжтэй хамруулна.

Тоглоом

ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Илбэчин мод”

Марчаахай студи ТББ



Санхүүжилт
Сангаас
19.95
сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023-2024



Төслийн явц:
40%



Үр дүн

**5-12 насныханд зориулсан
хүүхэлдэйн анимейшн**

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“ЖИМСНИЙ МОДНЫ ЗАЛГАА, ҮРЖҮҮЛЭГ АРЧИЛГАА”

Төсөл хэрэгжүүлэгч:
Гурван сээр ХХК

Төслийн товч мэдээлэл:

Төслийн хүрээнд 200-250 хүн Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байрлах Эрхэт жимсний аж ахуй, мод үржүүлгийн талбайтай танилцаж, алим, чавганы модны үржүүлэг, залгалт агротехник, арчилгааны практик сургалтад хамрагдах боломжтой болно.


Уг сургалтад хамрагдсанаар Монгол орны цаг уур, төвийн бүсэд дасан зохицсон, гарал үүсэл, зүйл, сорт нь тодорхой жимсний модыг сонгох мэдлэгтэй болох юм. Мөн жимсний модыг залгаж ургуулж сурах нь хүйтэн, ганд тэсвэртэй модыг бий болгох, жимс өгөх хугацааг богиносгодог, жимсний төрөл зүйл нь өөрчлөгдөхгүй байх давуу талуудтай байдаг байна.

+22

ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Жимсний модны залгаа, үржүүлэг арчилгаа”

Гурван сээр ХХК



Санхүүжилт
Сангаас
20
сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023



Төслийн явц:
70%



Үр дүн

**200 хүнд жимсний модныг залгаасаар
ургуулах практик сургалт
Сургалтын видео контент**

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

**“ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫГ
МОД ҮРСЭЛГЭЭНИЙ ГАЗАР
ОЛГОХ НЬ”**

Төсөл хэрэгжүүлэгч:
Миний клуб ТББ

Төслийн товч мэдээлэл:

Төслийн хүрээнд 1500 оюутан, сурагчдад 28 удаагийн 168 цагийн практик сургалтыг сайн дурын ажил хэлбэрээр мод үрсэлгээний талбай дээр орох юм.

Ингэснээр сурагч, оюутнууд хэрхэн мод үрслүүлэх, түүнийг хэрхэн арчилж ургуулах, хэрхэн боож багцлах, хэрхэн ойн нөхөн сэргээлт, хашаалалт хэрэм болгон тарьж ургуулах талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг олж авах юм.

MYCLUB
online community

ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Экологийн боловсролыг Мод үрсэлгээний газар олгох нь”
Миний клуб ТББ



Санхүүжилт
Сангаас
20
сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023 -2024



Төслийн явц:
50%



Үр дүн

2000 оюутан залуучуудад экологийн практик сургалт

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

**“ОРЧНОО
НОГООРУУЛАХ БҮТЭЭЛЧ
ТАВАН ШИЙДЭЛ”**

Төсөл хэрэгжүүлэгч:
Уур амьсгалын аян ТББ

Climate Campaign

Төслийн товч мэдээлэл:

Төслийн хүрээнд хотын орон зайд аль болох байгалийн бус материалуудыг багасгах, барилгажсан, цементлэгдсэн орон зайг эргүүлэн ургамал, ногоон бүрхэвч, мод, цэцэг гэх мэт байгалийн элементээр дахин амьдруулах 5 төрлийн бүтээлч шийдэл боловсруулан гарын авлага боловсруулж, орчноо тохижуулж цэцэрлэгжүүлэхийг хүссэн хэн бүхэн авч хэрэглэх боломжтой байхаар сошиал болон онлайн орчинд түүгээх, кампанит ажил өрнүүлэх юм.

**орчноо НОГООРУУЛАХ
5 БҮТЭЭЛЧ
ШИЙДЭЛ**


Байгалийн бус орон зайг бүтээхээр ногооруулах гарын авлага

www.creatives00.mn

ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Орчноо ногооруулах бүтээлч таван шийдэл”

Уур амьсгалын аян ТББ



Санхүүжилт
Сангаас
19.8
сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023



Төслийн явц:
60%



Үр дүн

“Орчноо ногооруулах бүтээлч 5 шийдэл” гарын авлага
Олон нийтэд хүргэх постер, видео, цуврал мэдээлэл

Шалгарсан ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

“ЦЭНХЭР ТОЛБО”

Төсөл хэрэгжүүлэгч:
Про медиа нетворк ХХК - Тэнгэр ТВ

Төслийн товч мэдээлэл:

Төслийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, түүнтэй холбоотой дотоод болон гадаадын орчинд өрнөж буй үйл явдлуудыг сурталчлах, олон нийтийн мэдээ мэдээллийг нэмэгдүүлэх, боловсролыг сайжруулах чиглэлээр тогтмол, тасралтгүй контент бэлтгэх зорилготой мэдээллийн хөтөлбөр гаргах юм.

ТЕНГЭР HD TELEVISION

WE ARE HIRING
ДИЗАЙНЕР
TENGER TV

6 ХҮН ТУТМЫН 1 БОСГО ОНДОГОО ДАРСАНГҮЙ


БУДААТАЙ ХУУРГАНЫ ҮНЭ ЕСЛӨӨ

ИГЭДИЙН ТӨЛСӨН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТЭГИЙН 2% БЭЛЭН МӨНГӨӨР ХУРИМТЛУУЛНА

ЧИГЛЭЛ 3: Олон нийтэд тогтвортой хөгжил, экологийн боловсрол олгох төслүүд

“Цэнхэр толбо”

Про медиа нетворк ХХК - Тэнгэр ТВ



Санхүүжилт
Сангаас
20
сая



Төсөл хэрэгжих хугацаа:
2023-2024



Төслийн явц:
20%



Үр дүн

**Экологи, тогтвортой хөгжлийн мэдлэг олгох
12 цуврал нэвтрүүлэг**

Санхүүгийн ҮЗҮҮЛЭЛТ

Хуримтлагдсан

5.925

тэрбум төгрөг


2022 оны 5-р сарын 1-ээс 2023
оны 7-р сарын 31-ний байдлаар



5,925,651,085₮

2022-2023 оны төслийн нээлттэй сонгон
шалгаруулалтын хүрээнд (сая төгрөг)

Төсөв, санхүүжилт	Чиглэл 1	Чиглэл 2	Чиглэл 3	Нийт
2022-2023 оны төслийн нээлттэй сонгон шалгаруулалтын төсөв	600.00	1,000.00	200.00	1,800.00
Шалгарсан төслүүдийн төсөв (Сангаас)	600.00	524.27	139.75	1,264.02
Хамтын санхүүжилт (Төсөл хэрэгжүүлэгчээс)	0.00	288.44	17.79	306.23
Хэрэгжиж буй төслүүдийн нийт үнэлгээ	600.00	812.71	157.54	1,570.25
Төслүүдэд олгогдсон байгаа санхүүжилт	360.00	208.21	55.70	623.91



2023 оноос санхүүжилт олгох стратегийн чиглэл



**Тогтвортой ой,
газар ашиглалтын
санхүүжилтийн
хөтөлбөр**

Хэрэгслүүд:
Грант, зээл, баталгаа,
хөрөнгө оруулалт



**Бичил төслийн
санхүүжилтийн
хөтөлбөр**

Хэрэгслүүд:
Грант




**Чадавхжуулах
хөтөлбөр**

Хэрэгслүүд:
Инкубатор, тэтгэлэгт
хөтөлбөр



Тогтвортой ой, газрын менежментийн санхүүжилтийн хөтөлбөр



Төсөл, судалгаа

Төсөл боловсруулах грант

Техникийн үнэлгээ,
зах зээлийн судалгаа,
санхүүгийн болон байгаль
орчны нөлөөллийн
тооцоолол, төслийн
материал бэлтгэх

Туршилт

Туршилтын төслийн грант

Тодорхой бүс нутагт
төслийг туршилтын
байдлаар хэрэгжүүлж,
үр дүнг хэмжих

Эхлэлтийн үе

Эхлэлтийн хөрөнгө оруулалт

Компанийн үйл
ажиллагааг эхлүүлэхэд
дэмжлэг үзүүлэх

Өсөлт

Зээл, эрсдэл хуваалцах бүтээгдэхүүн

- Үр дүнд суурилсан
урамшуулал, хүүгийн
татаас
- Баталгаа
- Хөнгөлөлттэй зээлийн
эх үүсвэр

Дэлхийн зах зээлд


Карбон кредит, ногоон бонд, ногоон IPO хийх

- Карбон тооцуулах
- Ногоон бонд гаргах
- Ногоон IPO хийх
- Хувьцаагаа зарах

Сангаас хэрэгжүүлэх

МНСК, дотоодын санхүүгийн байгууллагууд, гадны
санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

Төслийн сонгон шалгаруулалтын үйл явц



Цаашид төслийн саналыг тодорхой хугацаагаар тогтмол хүлээж авах бөгөөд төслийн сонгон шалгаруулалтын үйл явц нь төслийн төрлөөс хамааран 3-6 сар хүртэл үргэлжилдэг.


Сонгол шалгаруулалтын үйл явц дараах үндсэн чиглэлээс бүрдэнэ:

1. Төслийн санал хүлээн авах
2. Төслийн бүрэн санал боловсруулах, техникийн болон санхүүгийн үнэлгээ хийх
3. Санхүүжилтийн шийдвэр гаргах
4. Төслийг хэрэгжүүлэх, эргэх холбоотой ажиллах

Төслийг ирсэн хугацааны дарааллаар танилцаж, үнэлгээг хэрэгжүүлнэ.



Холбоо барих



Цахим шуудан: info@billiontree.mn
Вебсайт: www.billiontree.mn
Фейсбүүк: Тэрбум мод сан
Инстаграм: [Instagram.com/terbummodsan](https://www.instagram.com/terbummodsan)
LinkedIn: www.linkedin.com/company/billion-tree-fund

Хаяг: 904 тоот,
Парк плейс оффис,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот, Монгол улс

